

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 5 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно. Үүнд:

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийн санг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд хөрвүүлэх программын хөгжүүлэлтийг 05 дугаар сарын 30-ны өдөр дуусгаж, үйл ажиллагааны бэлэн байдлыг хангалаа. Визийн зөвшөөрлийн хүсэлт илгээх болон хүлээн авах төлбөрийн модулийг хэсэгчлэн гүйцэтгэж, хүсэлтийг хуваарилах, ажилтны хандах эрх үүсгэх тохиргоог уг системд оруулсан.

2.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.

Хэрэгжилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авах Авлигатай тэмцэх газрын 976-110, өргөдөл гомдол хүлээн авах байгууллагын 70133480, дотоод хяналт шалгалтын 70133464 дугаарын утсыг нийтэлсэн сурталчилгааны хуудас (постер)-ыг англи, монгол хэл дээр төв байгууллага, харьяа нэгжүүдийн үйлчилгээний заал, хилийн боомтуудын байранд тус тус байршуулж, байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түгээлээ.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” 46 дугаар мэдэгдлийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг байгууллагын даргын 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/885 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст хүргүүлэв.

3.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

Хэрэгжилт: Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын

төлөвлөгөөний дагуу 05 дугаар сард “Стресс менежмент”, “Жендэрийн хэвшмэл ойлголт ба жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Сэтгэл зүйгээ удирдах нь”, “Удирдах албан тушаалтны харилцаа хандлага ба ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт нийт 4 удаагийн сургалтыг сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 350 албан хаагчийг хамруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 05 дугаар сард 77 хувь буюу 3.9 оноотой дүгнэгдлээ.

Тус үйл ажиллагааны хөтөлбөрийн “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээ 30 хувьтай, бусад арга хэмжээ 100 хувьтай үнэлэгдсэн.

“Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээ хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилт тавьсан тул уг арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР